



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 19-ны өдөр

Дугаар А/26

Эрдэнэт

Г “Эрүүл мэнд цахим гүйлт” биеийн тамирын  
арга хэмжээг эрчимжүүлэх тухай Г

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Засгын газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5 дахь заалт, Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөртэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3.1.11 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэнд цахим гүйлт” биеийн тамирын арга хэмжээний үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээг эрчимжүүлж үр дүнтэй, хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Шаардлагатай санхүүгийн зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 03 дүгээр сарын  
19-ний өдрийн 128 дугаар  
нэгдүгээр тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

- Ниймийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд :

- Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
- Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан
- Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
- Халдварт бус өвчин, тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан
- Зураглаач

**БИЕИЙН ДАРХЛААГ ДЭМЖИХ “ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ ГҮЙЛТ 2021”  
БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Зорилго:** Эрүүл мэндийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, таниулах, хүсэл, сонирхлыг бий болгох, дэмжих, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах, арга хэмжээг сурталчлахад оршино

**Хугацаа:** 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустал

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Орхон аймгийн Эрүүл мэндийн газар-НЭМТөв

**Хамтран ажиллах байгууллагууд:** ЭМБ-ууд

**Хамрах хүрээ:** ЭМБ-уудын ажилтан албан хаагчид

**Шагнал урамшуулал:**

1-р байр – Цом, өргөмжлөл

2-р байр - Өргөмжлөл

3-р байр – Өргөмжлөл

Шилдэг эрэгтэй гүйгч - Өргөмжлөл

Шилдэг эмэгтэй гүйгч – Өргөмжлөлөөр тус тус шалгаруулж урамшуулна.

**Үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ЭМБ-уудыг шалгаруулах үзүүлэлтүүд:**

1. Байгууллагын нийт ажилчдын тоо
2. “Орхоны гүйгчид-2021” нээлттэй фэйсбүүк групп хаягт нэгдсэн ажилтны тоо
3. STRAVA апплейкшн татаж суулгасан ажилтны тоо
4. БЖИ-г тодорхойлсон ажилтны тоо  
/Нийт ажилтны 0-25% биелүүлсэн бол 1 оноо  
Нийт ажилтны 26%-50% биелүүлсэн бол 2 оноо  
Нийт ажилтны 51%-75% биелүүлсэн бол 3 оноо  
Нийт ажилтны 76%-100% биелүүлсэн бол 4 оноо/
5. Тухайн байгууллагын нийт ажилтны тоог туулсан замын нийт километрт харгалзуулсан оноог дараах байдлаар өгнө.
  - 0.001-10.000 км зам туулсан бол 1 оноог
  - 10.001-15.000 км зам туулсан бол 2 оноог
  - 15.001-20.000 км зам туулсан бол 3 оноог
  - 20.001-25.000 км зам туулсан бол 4 оноог
  - 25.001-30.000 км зам туулсан бол 5 оноог
  - 30.001-35.000 км зам туулсан бол 6 оноог
  - 35.001-40.000 км зам туулсан бол 7 оноог
  - 40.001-45.000 км зам туулсан бол 8 оноог

- 45.001-50.000 км зам туулсан бол 9 оноог
- 50.001-55.000 км зам туулсан бол 10 оноог
- 55.001-60.000 км зам туулсан бол 11 оноог
- 60.001-65.000 км зам туулсан бол 12 оноог
- 65.001-70.000 км зам туулсан бол 13 оноог
- 70.001-75.000 км зам туулсан бол 14 оноог
- 75.001-80.000 км зам туулсан бол 15 оноог
- 80.001-85.000 км зам туулсан бол 16 оноог
- 85.001-90.000 км зам туулсан бол 17 оноог
- 90.001-95.000 км зам туулсан бол 18 оноог
- 95.001-100.000 км зам туулсан бол 19 оноог
- 100.001-ээс дээш км туулсан бол 20 оноог өгнө.

**Шалгаруулах журам:**

1. Шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу материалыг бүрдүүлэн 2021 оны 03 сарын 29-ны өдөр ЭМГ-т бичгээр болон цахимаар /munguunasaa@gmail.com/ ирүүлнэ.
2. ЭМГ газарт ирүүлсэн материалтай танилцаж онооны нийлбэр дүнг гаргана.
3. Байгууллагын нийт ажилдын тоо, эрүүл мэндийн цахим гүйлтэд оролцож, STRAVA апплейкшн татаж гүйсэн гүйлтийн нийт километрийн нийлбэрийг харцуулан дүгнэнэ.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран зохион байгуулагч
1.	Аяны удирдамж, төлөвлөгөө батлуулж хамтран зохион байгуулагч байгууллагуудад хүргүүлэх	3 сарын 19	ЭМГ	ЭМБ-ууд БСУГ
2.	"Орхоны гүйгчид-2021" нээлттэй фэйсбүүк группт ажилтан, албан хаагч бүр нэгдэж STRAVA апплейкшн татаж суулгасан байх	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
3.	Дасгал хөдөлгөөнөөр бие бялдрыг чийрэгжүүлэх, дархлаажуулах үйл явцыг өргөнөөр сурталчилах	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
4.	Байгууллагын ажилчдын БЖИ-г тодорхойлох	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
5.	"Эрүүл мэнд цахим гүйлт 2021" арга хэмжээнд оролцож бусад байгууллагуудыг уриалах, цахим давалгаа бий болгох	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
6.	Нээлттэй фэйсбүүк групп, цахим хуудсанд байршуулсан мэдээг бусдад хуваалцах, уриалах	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
7.	Өдөр бүрийн гүйлт болон алхалтыг баримтжуулж тайланд үнэн зөв тусгах	3 сарын 19 – 3 сарын 28	ЭМБ-ууд	ЭМГ
8.	"Эрүүл мэнд цахим гүйлт 2021" арга хэмжээнд оролцсон байгууллага хамт олны үйл ажиллагааны тайланг ЭМГ-т ирүүлэх	3 сарын 29	ЭМБ-ууд	ЭМГ

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХБӨТСХМ  
ХЯНАСАН: НЭМТАМ

*Handwritten signature*

Н.МӨНГӨНЦАЦРАЛТ  
А.БАЯРХҮҮ

Төсөв санхүүжилт :

№	Шагнал урамшуулал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цом	1	35.000	35.000
2	Өргөмжлөл /байгууллага/	3	50.000	150.000
3	Өргөмжлөл /шилдэг гүйгч/	2	30.000	60.000
Нийт 245.000 төгрөг				

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:

ХБӨТСХМ:  Н.МӨНГӨНЦАЦРАЛТ

ХЯНАСАН:

ЭМГ-ЫН НЯГТЛАН БОДОГЧ:  Н.ЧУЛУУН ЭРДЭНЭ